



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар

А/206.

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гурван сэнхэр төвтэй таван од аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, аймгийн аялал жуулчлалын мэдээллийг цахим хуудсаар дамжуулан дотоод болон гадаадын жуулчдад сурталчлах, салбарын ажилчдад сургалт зохион байгуулах, аймгийн аялал жуулчлалын зөвлөгөөн зохион байгуулах зэрэг төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажилд зориулан 30,000,000 төгрөгийг батлан зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 30,000,000 төгрөг (гучин сая)-ийг Хөшөөт хөгжлийн сангийн 5.3-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль"-ийн хүрээнд зохион байгуулж, гүйцэтгэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах, тайлагнах эрхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Б.Сандагсүрэн)-д шилжүүлсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



8400 01 1107  
Zah A/206/Kh